

Өврийн дэвтэр 2017 он

Өврийн дэвтэр
нийн



Өврийн дэвтэр

2018 он



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ



ГАЗАР НУТГИЙН ХЭМЖЭЭ:

45 704.89 КВ.КМ

2018 ОН



- Аймгийн ерөнхий мэдээлэл.....2
- Хүн амын үндсэн үзүүлэлт.....15
- Дотоодын нийт бүтээгдэхүүн.....22
- ААНБ-ын тооллогын үзүүлэлт..... 24
- Засаг даргын мөрийн хөтөлбөр.....27
- Аж үйлдвэрийн үзүүлэлт.....28
- Эрүүл мэндийн зарим үзүүлэлт.....29
- Ажил эрхлэлтийн зарим үзүүлэлт....34
- Боловсролын зарим үзүүлэлт36
- Мал аж ахуйн зарим үзүүлэлт.....39
- Аймгийн холбоотой ВЭБ хуудас.....61



Баян-Өлгий аймаг нь 1940 оны 8 дугаар сард БНМАУ-ын Бага Хурлын шийдвэрээр “Баян-Өлгий” аймаг байгуулагджээ.

Баян-Өлгий аймаг нь Монгол улсын хамгийн баруун хэсэгт оршдог бөгөөд 13 сум, 90 багтай ба хойд талаараа ОХУ-тай 225 км, баруун урд талаараа БНХАУ-тай 450 км, зүүн хойд талаараа Увс аймагтай 165 км, зүүн урд талаараа Ховд аймагтай 450 км тус тус хиллэн оршдог. Улаанбаатар хотоос 1709 км зайтай. Монгол улсын хэмжээнд нийтдээ 45 704.89 МЯНГАН КВ.КМ нутаг дэвсгэртэй. Хүн амын дийлэнх хувийг казах үндэстэн эзэлдэг. 2017 оны жилийн эцсийн байдлаар 101 591 хүн амтай, үүнээс 45 123 хүүхэд багачууд амьдарч байна.

Уур амьсгал

Байгаль цаг уурын хувьд эрс тэс эх газрын уур амьсгалтай, өвөлдөө -36-42 градус хүртэл хүйтэрдэг, дулааны улиралд халуун нь 37-40 градус юм. Хур тундасны уналт янз бүр, жилийн дундаж агаарын чийгшилт 52.7%. Салхины чиглэл хойд, баруун хойд, баруунаас хурд нь 9-25 м/сек байх ба салхины ихэнх нь хавар, намрын улиралд тохиолдоно.



Ёс заншил, өв уламжлал

Баян-Өлгий аймгийн онцлог соёлын биет бус өв

- Эх хэл, аман зохиолын илэрхийлэлүүд
 - Айтыс (ерөөл, магтаал)
 - Язгуур урлаг (домбор, сыбызгы, сазсырнай)
 - Гар урлал, ардын дуу
 - Зан үйл (Хүүхэд өлгийдөх, казах хурим, бүргэдээр ан авах ёс г,м)
 - Баяр ёслол (Наурыз, бүргэдчдийн баяр)
 - Цагаан идээ боловсруулах
- Казах үндэсний хээ угалз гэх зэрэг онцлог өв олонтой

Баян-Өлгий аймгийн хэмжээнд соёлын биет бус өв уламжлагч 348 нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй.Соёлын биет бус өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авьяастан улсын жагсаалтад Баян-Өлгий аймгаас 6 өвлөгч байдаг.



Алдар цуутай хүмүүс

- Монгол Улсын Ардын цолтолтнууд 9
- Монгол Улсын Төрийн соёрхолтнууд 7
- Монгол Улсын баатар 1
- Хөдөлмөрийн баатар 27
- Монгол Улсын гавьяат цолтон 95

Гадаад орны алдар цол, одон медалиар шагнагдагсад
Цол:

- 1.Дорнод Түркистаны Ардын баатар Ш.Картенбай
- 2.Казахстаны Урлагийн Гавьяат зүтгэлтэн А.Хабылаш
- 3.Тыва улсын гавьяат жүжигчин Х.Чапай
- 4.Тыва улсын Гавьяат багш А.Ариунаа



БИЕИЙН ТАМИР, СПОРТ

Төрөл	2017
Биеийн тамир, спортын байгууллага	1
Нийт ажиллагчид	19
Эмэгтэй	6
Биеийн тамир, спортоор хичээллэгчид	9690
Спортын заал	33
Дасгалжуулагчид	580
Эмэгтэй	128
Олон улсын мастер	9
Спортын мастер	82
Цол зэрэгтэй шүүгчид	195
Эмэгтэй	24



Биеийн тамир, спорт

- Баян-Өлгий аймгаас төрөн гарсан улсын цолтой бөхчүүд 8, спортын гавьяат цолтон 2, олон улсын хэмжээний мастер 9, спортын мастер 82, спортын дэд мастер 70, спортын зэрэг цолтон 417, улсын шүүгч 10, зэрэгтэй шүүгч 185 байна.
- Тив, дэлхий, олон улс, монголын бүх ард түмний спартикад, хүүхдийн спортын наадам, улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд тамирчид амжилттай оролцож, 19 алт, 28 мөнгө, 32 хүрэл, нийт 79 медаль хүртэж байна.





Биеийн тамир, спорт



- 2017 онд Өсвөрийн улсын аварга шалгаруулах, Олон улс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд хөнгөн атлетик, жудо бөх, чөлөөт бөх, үндэсний сур, волейбол, казак күрес, гардан тулаан, хүндийн өргөлт, үндэсний бөх, таеквондо, аударыспах /морин дээрх барилдаан/, теннис, дугуй, шагай харваа, спорт аялал гэсэн 12-н төрлөөр 200 гаруй тамирчин ажилттай оролцож алт-7, мөнгө-8, хүрэл-21 нийт-36 медаль хүртсэн
- Нийт 2017 онд УАШТ, ОУ, Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс 79 медаль хүртсэн амжилттай.



Соёл, сүм хийд



- Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт 74
- Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчид 22100
- Нийтийн номын сан 14
- Нийтийн номын сангийн суудал 316
- Номын сангийн байнгын уншигчид 15794
- Сүм хийд 20
 - Ислам 20





Нутгийн брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ

- Монгол улсын түүхэнд анх удаа “ Бүргэдийн баяр” арга хэмжээг жил болгон тогтмол зохион байгуулж байна. Тус арга хэмжээ хамгийн олон бүргэдчинг оролцуулсан арга хэмжээ болж хэвшсэн. Энэхүү баярын хүрээнд орон нутгийн онцлог, өвөрмөц соёлыг шингэсэн хатгамал эдлэл, бэлэг дурсгалын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж байна.
- Аймгийн Засаг даргын оны А/294 тогтоолоор “ Үндэсний нэрийн бүтээгдэхүүн”-ийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулж, аймгийн нэрийн бүтээгдэхүүнээр Акбоар ХХК-ний вакуумдсан казыг шалгаруулсан.
- Тус аймгийн хэмжээнд хатгамал эдлэл, Алтанцөгц сумын зөгийн бал, чацаргана, вакуумдсан каз, Буянт сумын савласан сүү, цагаан идээ зэрэг орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



Нутгийн брэнд бүтээгдэхүүн





АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТАЛААР



Улаанбаатар хотод Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд аялал жуулчлалын чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 9 аж ахуйн нэгж, байгууллагууд хамтран оролцож, өөрсдийн бүтээгдэхүүн, байгууллагын үйл ажиллагаагаа танилцууллаа. “Бүргэдийн баяр-2017” арга хэмжээг уламжлал ёсоор 18 дахь удаагаа зохион байгууллаа. Уг арга хэмжээнд тус аймгийн 13 сумаас 120 бүргэдчин оролцлоо. Энэ удаагийн арга хэмжээнд дэлхийн 20 гаруй орноос буюу Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайдууд хөрш аймгийн удирдлагууд зэрэг гадаад дотоодын 1200 орчим жуулчин ирж сонирхсон ба энэ нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй гарсан.



ТЭЭВЭР

Төрөл	2017
Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан авто машин бүгд	13 722
Суудлын авто машин	10 140
Ачааны автобус	2 819
Автобус	615
Тусгай зориулалтын	148
Ашигласан хугацаагаар	
3 жил хүртэл	105
4-9 жил	1 777
10-аас дээш жил	11 840



БАРИЛГА, ОРОН СУУЦ, НИЙТИЙН АЖ АХУЙ

Төрөл	2017
Дотоодын барилгын байгууллагуудын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажил (сая.төг)	27 469.4
Ус түгээх цэгийн тоо	16
Зөөврийн ус хэрэглэдэг өрх	10 331
Ус тээврийн машины тоо	2
Хог устгах цэг	17
Хог тээврийн машины тоо	42
Халуун усны цэгийн тоо	46



БАЙГАЛЬ ОРЧИН

Төрөл	2017
Ойн сан бүхий газар (мян.га)	68.083
Ойн модоор бүрхэгдсэн газар	67.863
Ой модыг огтолсон газар	477
Ангийн отог	15
Ангийн бүс нутаг	16
Мод үржүүлгийн газар	10
Ой тэлэн ургах нөөц газар	86
Ойн сангийн бусад газар	220



ГЭМТ ХЭРЭГ

Төрөл	2017
Бүртгэгдсэн гэмт хэрэг бүгд	319
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	171
Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	65
Малын хулгайн гэмт хэрэг	17
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг	14
18 хүртэлх насны	7
Шүүхээр шийтгүүлсэн хүн	212



МӨНГӨ, БАНК, ТӨРИЙН САНХҮҮ

Төрөл	2017
МӨНГӨ, БАНК	(сая.төг)
Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл	83711.6
Зээлийн өрийн үлдэгдэл	132869.1
Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	1 928.9
ТӨРИЙН САНХҮҮ	(сая.төг)
Орон нутгийн төсвийн нийт орлого	10 505.4
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон санхүүгийн дэмжлэг	12 106.3
Орон нутгийн төсвийн нийт зарлага	71329.3
Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	49 027.0
Улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлэг	1 654.0



Хүн амын тоо, насны бүлгээр, 2017 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн ам	0-14	15-64	65+	Эрэмбэ
Өлгий	35118	11430	22666	1022	I хамгийн их
Алтай	4257	1459	2664	134	
Алтанцөгц	2814	935	1776	103	XIII хамгийн бага
Баяннуур	4978	1789	3010	179	
Бугат	3790	1346	2313	131	
Булган	5183	1750	3224	209	
Буянт	2846	932	1817	97	
Дэлүүн	7331	2564	4521	246	V
Ногооннуур	7976	2992	4746	238	IV
Сагсай	5259	1931	3125	203	
Толбо	4169	1447	2555	167	
Улаанхус	8548	3167	5090	291	III
Цэнгэл	9322	3461	5619	242	II
Нийт	101591	35203	63126	3262	



Насны бүлгийн эзлэх хувь, 2017 он, сумдаар

Сумдын нэр	Нийт хүн амд хүүхдийн эзлэх хувь	Хөгшидийн эзлэх хувь	Хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь
Өлгий	32.5	2.9	64.5
Алтай	34.3	3.1	62.8
Алтанцөгц	33.2	3.7	63.1
Баяннуур	35.9	3.6	60.7
Бугат	35.5	3.5	61
Булган	33.8	4	62.2
Буянт	32.7	3.4	63.8
Дэлүүн	35	3.4	61.7
Ногооннуур	37.5	3	59.5
Сагсай	36.7	3.9	59.4
Толбо	34.7	4	61.3
Улаанхус	37	3.4	59.5
Цэнгэл	37.1	2.5	60.3
Нийт	34.7	3.2	62.1



Хүн ам, сумаар 1990 – 2017 он

Сумдын нэр	1990	1995	2000	2005	2010	2015	2017	Эрэмбэ
Өлгий	29381	21413	25763	28248	29068	35124	35118	I хамгийн их
Алтай	3847	3492	4016	3914	3752	4209	4257	
Алтанцөгц	3344	2885	3168	3038	2754	2858	2814	XIII хамгийн бага
Баяннуур	6132	4643	5140	5320	4546	5065	4978	
Бугат	3238	3124	3541	3604	3290	3682	3790	
Булган	5679	5243	5916	5901	5486	5423	5183	
Буянт	2865	2715	3060	3002	2437	2736	2846	
Дэлүүн	7501	7054	8347	8183	6461	7924	7331	V
Ногооннуур	11939	8516	8947	8067	7397	6369	7976	IV
Сагсай	4765	4900	4876	5185	4739	5111	5259	
Толбо	4533	4086	4773	4260	3785	4108	4169	
Улаанхус	7589	7141	8437	8672	7318	8453	8548	III
Цэнгэл	7298	7047	8110	8364	8158	9194	9322	II
Нийт	98111	82259	94094	95758	89191	101183	101591	



Өрх, сумаар 2005 – 2017 он

Сумдын нэр	2005	2010	2015	2016	2017	Эрэмбэ
Өлгий	6289	6627	7637	7792	8000	I хамгийн их
Алтай	1022	1067	1093	1122	1108	
Алтанцөгц	701	706	736	749	747	XIII хамгийн бага
Баяннуур	1153	994	1088	1151	1155	
Бугат	865	852	926	972	989	
Булган	1195	1196	1182	1183	1188	
Буянт	715	613	747	768	791	
Дэлүүн	1744	1503	1466	1594	1634	
Ногооннуур	1839	1720	1866	1951	1989	II
Сагсай	1121	1101	1202	1250	1281	
Толбо	961	855	947	970	967	
Улаанхус	1888	1611	1746	1819	1796	IV
Цэнгэл	1835	1785	1941	2001	1981	III
Нийт	21328	20630	22577	23322	23626	



Хүн ам, нийгмийн үзүүлэлтүүд

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017
Хүн амын тоо	93165	97787	99346	101591
Төрсөн хүүхэд- бүгд	2789	2770	2831	2849
1000 хүнд ногдох төрөлт	30.7	28.3	28.5	28.0
Нас барсан- бүгд	470	534	515	448
1000 хүнд ногдох нас баралт	5.2	5.5	5.2	4.4
Цэвэр өсөлт: 1000 хүнд ногдох	25.5	22.8	23.3	23.6
Эдийн засгийн идэвхитэй хүн ам	46.4	49.5	43.9	51.9
Ажиллагсдын тоо	35.9	43.6	42.9	45.5
Ажилгүйчүүд	1534	1124	1320	1207
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	22.5	11.9	9.3	6.4
Ажилгүйдлийн түвшин/ХХҮГазар/	3.3	2.3	3.0	2.3
Ажилгүйдлийн түвшин/АХСудалгаа/	48.5	24.0	21.2	12.3




Хүн ам, нийгмийн үзүүлэлт

Үзүүлэлтүүд	2014	2015	2016	2017
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	22.5	11.9	9.3	6.4
Ядуу өрхийн тоо	6686	6923	7184	8127
Нэн ядуу өрхийн тоо	2844	3697	3993	4313
8 ба дээш ам бүлтэй өрх	945	726	1054	1119
Өрх толгойлсон эмэгтэй	1814	1871	1822	1879
Ганц бие өрхийн тоо	186	207	254	504
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	4461	4516	4564	4564
Хагас өнчин хүүхдийн тоо	1904	1842	1862	1937
Бүтэн өнчин хүүхдийн тоо	253	281	273	283




2017 онд монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2%, баруун бүсийн 21.1% болох 329.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 3.3 сая төгрөг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дүнгээр 58.9 тэрбумд хүрсэн байна.





ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН





ДНБ-ийг салбараар авч үзвэл: ХАА, ан агнуур, ойн аж ахуйн салбар 35.3%, Аж үйлдвэр, барилгын салбар нь 17.9%, Үйлчилгээний салбар 46.8%-ийг тус тус эзэлж байна. Нэг хүнд ногдох ДНБ нь 2014 онд 3.1 сая, 2015 онд 3.2 сая, 2016 онд 3.1 сая, 2017 онд 3.3 сая төгрөгт хүрсэн байна.

ДНБ-д эзлэх салбаруудын эзлэх хувь





АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА – 2017 ОН



2017 оны жилийн эцсийн байдлаар 1799 аж ахуйн нэгж, байгууллагын 1344 нь буюу 74.7 хувь нь аж ахуйн нэгж, 279 буюу 15.5 хувь нь төрийн бус байгууллага, 176 буюу 9.8 хувь нь төсвийн байгууллага байна.



Аж ахуйн нэгж, байгууллагын тоо

Сумын нэр	2006	2011	2016	2017
Алтай	19	28	45	50
Алтанцөгц	14	25	35	40
Баяннуур	28	48	56	65
Бугат	12	21	36	42
Булган	17	32	52	52
Буянт	20	28	39	47
Дэлүүн	31	54	68	75
Ногооннуур	23	59	99	114
Сагсай	16	22	43	42
Толбо	23	31	49	54
Улаанхус	22	52	65	77
Цэнгэл	31	48	67	66
Өлгий	337	563	916	1075
Дүн	593	1011	1570	1799



Аж ахуйн нэгж, байгууллагын тоо 2017 он

Сумын нэр	Нийт ААНэгж, байгууллага	Аж ахуйн нэгж	Төсөвт байгууллага	Төрийн бус байгууллага
Алтай	50	37	9	4
Алтанцөгц	40	27	6	7
Баяннуур	65	46	8	11
Бугат	42	33	6	3
Булган	52	34	9	9
Буянт	47	29	6	12
Дэлүүн	75	60	10	5
Ногооннуур	116	92	15	9
Сагсай	42	30	8	4
Толбо	54	39	6	9
Улаанхус	77	53	10	14
Цэнгэл	66	43	10	13
Өлгий	1073	821	73	179
Дүн	1799	1344	176	279



АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА –ын
ажиллагчдын сарын дундаж цалин



591.000

мянган төгрөг



607.400 МЯН.ТӨГ



575.300 МЯН.ТӨГ



Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Эдийн засгийн тогтвортой хөгжил

Хөдөө аж ахуй

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, стандартчилал

Геологи, уул уурхай, хүнд үйлдвэр

Барилга, хот байгуулалт

Эрчим хүч, цахилгаан

Мэдээлэл харилцаа, холбоо

Зам, тээвэр

Хүн амын соёл, урлаг спортын үйлчилгээ

Боловсрол, гэр бүл, хүүхдийн байгууллагуудын хөгжих орчин

Хүн амын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

Гадаад харилцаа

Төрийн үйлчилгээ – Хариуцлага, сахилга, ажлын чадвар, ухаалаг үйлчилгээг төлөвшүүлнэ


Хууль эрх зүй

Батлан хамгаалах бодлого – бэлэн байдал



АЖ ҮЙЛДВЭР

2017 онд Аж үйлдвэрийн салбарын борлуулалтын 40.8 хувийг уул уурхай олборлох салбар, 29.0 хувийг боловсруулах салбар, 30.1 хувийг цахилгаан, дулаан усан хангамжийн салбар бүрдүүлж байна.





Эрүүл мэндийн зарим үзүүлэлт, 1995 – 2017 он

Үзүүлэлт	1995	2000	2005	2010	2015	2017
Их эмч	0	132	141	144	166	203
Эм зүйч	0	7	8	10	26	28
1000 хүнд ногдох төрөлт		32.3	23.0	22.8	29.7	28.7
Нэг сувилагчид ногдох хүн					341	322
1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдлийн түвшин		20	22	22.8	24.9	13.3
Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)		16.1	9.3	1.9	1.6	1.0
Үр хөндөлт					357	342
Халдварт өвчнөөр өвчлөгчид		673	402	731	614	332



Төрөлт, амьд төрөлт, нас баралтын тоо, жилийн эцсийн байдлаар,
сумдаар /2017 он/

Сумдын нэр	Төрөлт	Амьд төрөлт	Нас баралт
Алтай	103	103	13
Алтанцөгц	79	80	15
Баяннуур	140	141	16
Бугат	94	92	24
Булган	127	127	23
Буянт	79	80	18
Дэлүүн	207	205	32
Ногооннуур	201	201	32
Сагсай	158	159	19
Толбо	113	113	16
Улаанхус	278	279	36
Цэнгэл	282	283	49
Өлгий	934	937	143
Цагааннуур	49	49	12
Дүн	2844	2849	448



Нийгмийн зарим үзүүлэлт, 1995 – 2017 он

Үзүүлэлт	2000	2005	2010	2015	2017
Төрөлт	2933	2375	2459	2770	2849
Нас баралт	499	528	533	534	448
Дундаж наслалт	66.31	67.47	69.8	73.33	73.12
Бүтэн өнчин хүүхдийн тоо	229	383	355	281	283
Хагас өнчин хүүхдийн тоо	2666	3132	2515	1842	1937
Өрх толгойлсон эхийн тоо	1317	1487	2000	1871	1879
18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх				1001	1076
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх				2841	3362



Нийгмийн зарим үзүүлэлт, 2017 он

Үзүүлэлт	2017
18 хүртэлх насны 4, түүнээс дээш хүүхэдтэй өрх	3362
18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эх	1076
1000 хүнд ногдох төрөлт	28.7
1000 хүнд ногдох нас баралт	4.4
Хүн амын дундаж наслалт	73.12
Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн өвчтөн	27 371
10 000 хүн ам ногдох хорт хавдараар шинээр өвчлөгчид	3.1



2016

1822

2017

1879



Өрх толгойлсон эхийн тоо



273



283

Бүтэн өнчин хүүхдийн тоо



1862



1937

Хагас өнчин хүүхдийн тоо



188



220

Өрх үүсгэн ганц биеэр амьдардаг өндөр настан




Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт 2013 - 2017 он


Үзүүлэлт	2013	2014	2015	2016	2017
Хөдөлмөрийн насны хүн ам	51982	54650	56893	52014	59751
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	31204	32953	34016	43940	51973
Ажиллагчид	34285	35955	43621	39873	46578
Ажилгүй иргэд	10531	10425	5869	4067	6570
Эмэгтэй Бүртгэлтэй ажилгүй иргэд	1349	1527	1124	1320	1207
Эмэгтэй Ажиллах хүчний оролцооны түвшин	60	60.3	56.9	66.1	71.5
Ажил эрхлэлтин түвшин	95.1	56.2	63.4	59.9	62.7
Ажилгүйдлийн түвшин	4.3	4.6	3.3	9.3	12.4



Нийт хүн амд хөдөлмөрийн насны хүн амын эзлэх хувь, 2017 оноор



- Хүүхэд (0-14)
- Хөдөлмөрийн насны хүн ам (15-59)
- Тэтгэврийн насны хүн ам (60+)





Боловсролын үзүүлэлт

Сумын нэр	2013/2014	2014/2015	2015/2016	2016/2017	2017/2018
Алтай	845	781	827	794	802
Алтанцөгц	502	443	415	434	438
Баяннуур	1059	1033	1070	1055	1059
Бугат	411	392	420	444	458
Булган	1135	1079	1091	1027	1027
Буянт	469	455	479	475	441
Дэлүүн	1491	1468	1489	1436	1449
Ногооннуур	1125	1097	1106	1127	1143
Сагсай	987	966	979	934	979
Толбо	694	712	743	717	735
Улаанхус	1556	1460	1504	1557	1584
Цэнгэл	1889	1892	1955	1903	1938
Өлгий	9963	9685	10370	10487	10807
Цагааннуур	171	176	178	201	202
Дүн	22297	21639	22626	22591	23062
Хамран сургалтын хувь*	94.8	93.6	92.8	86.6	92.8

Тайлбар: Хамран сургалтын хувь суурь боловсрол эзэмших насны / 6-14 / хүүхдийн тооцоогоор



Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үндсэн багш **247**


Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад хамрагдсан хүүхэд **7110**




ЕБС-ийн 1 дүгээр ангид элсэгчид **2387**



ЕБС-д суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд **7702**, үүнээс эмэгтэй **4032**



- ЕБС-д суралцагчдаас дотуур байранд суух хүсэлт гаргасан
- Амьдарч буй хүүхэд




ЕБС-д суралцаж байгаа малчин өрхийн хүүхэд




ЕБС-ийн үндсэн багш

Техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчид





ЕБС, СӨБ-ийн байгууллагын тоо, сумдаар, 2017/2018 хичээлийн жилд





Малын тоо

Төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Бодоор*	261.0	302.6	326.5	377.5	446.3	487.6	528.6	548.4
Толгойн тоо	1126859	1302786	1410503	1604080	1883610	2021046	2167413	2226149
Тэмээ	3766	3992	4192	4348	4671	4717	4933	5279
Адуу	43451	48532	51705	58440	69562	77291	85783	93402
Үхэр	66049	80815	87198	105079	127443	144761	155623	161025
Хонь	459834	506911	574376	662827	799861	850620	937760	995222
Ямаа	553759	662536	693032	773386	882073	943657	983314	971221

2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Баян-Өлгий аймгийн 13 сумын 90 багт 2.2 сая толгой мал тоолуулж 2016 оныхоос 58.7 мянган толгой малаар буюу 2.7 хувиар өссөн байна. Мал сүрэг дөрвөн төрөл дээрээ өссөн үзүүлэлттэй байна.



Өрх, малчдын тоо, насны бүтэц, тэдний соёл, ахуйн байдал

Төрөл	2008	2009	2010	2011	2012
Малтай өрх	14998	14930	13862	13858	13520
Малчин өрх	9723	10380	9436	9334	8383
Малчдын тоо	22886	21141	18685	18895	17808
16-34 насны	12377	10589	9528	9037	8644
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	8795	8189	7195	7853	7902
Тэтгэврийн насны	1714	2363	1962	2005	1262
Нийт малчдаас эмэгтэй	7880	8110	8227	8040	8181
Насны бүрэлдэхүүн хувь	100	100	100	100	100
16-34 насны	54	50	51	47.9	48.5
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	38.4	38.8	38.5	41.5	44.3
Тэтгэврийн насны	7.5	11.2	10.5	10.6	7
Нийт малчдаас эмэгтэй хувь	34.4	38.6	44	42.5	45.9
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	157	125	119	168	191




Өрх, малчдын тоо, насны бүтэц, тэдний соёл, ахуйн байдал

Төрөл	2013	2014	2015	2016	2017
Малтай өрх	14104	14636	14608	15192	14976
Малчин өрх	8392	8921	8872	8888	9261
Малчдын тоо	17723	18302	18398	18411	17200
16-34 насны	8120	7693	7396	6927	6515
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	8249	9117	9433	9884	8823
Тэтгэврийн насны	1354	1492	1569	1600	1862
Нийт малчдаас эмэгтэй	8181	8458	8471	8712	7350
Насны бүрэлдэхүүн хувь	100	100	100	100	100
16-34 насны	45.8	42	40.2	37.6	37.9
35-аас тэтгэвэрт гарах хүртэл насны	46.5	49.8	51.3	53.7	51.3
Тэтгэврийн насны	7.6	8.2	8.5	8.7	10.8
Нийт малчдаас эмэгтэй хувь	46.2	46.2	46	47.3	42.7
Нэг малчин өрхөд ногдох малын тоо /толгойгоор/	191	211	227	243	128




Малын тоо, сумдаар








Мал сүргийн бүтэц, 2017 он



Бог малын дотор хонин сүрэг 44.7%, ямаан сүрэг 43.6%-ийг тус тус эзэлж байгаа нь уламжлалт сүргийн бүтэц алдагдаагүй хэвийн байгааг илэрхийлж байна.





2017 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2226149 толгой мал тоологдсон байна.



93402

5279



995222



161025




971221





Хамгийн олон малтай сумд



Цэнгэл 298 012

Дэлүүн 267 759

Ногооннуур 225 043


Улаанхус 215 179

Толбо 183 896






Малын төрлөөр нь авч үзвэл:






Малын төрлөөр нь авч үзвэл:






Малын төрлөөр нь авч үзвэл:






Малын төрлөөр нь авч үзвэл:






Малын төрлөөр нь авч үзвэл:







Малын төрлөөр нь авч үзвэл:






Малын төрлөөр нь авч үзвэл:





*Малын төрлөөр нь авч үзвэл:*

*Малын төрлөөр нь авч үзвэл:*



Малын төрлөөр нь авч үзвэл:





Гол нэрийн зарим барааны жилийн дундаж үнэ

- Хонины мах 4995 (кг)
- Үхрийн ястай мах 4309
- Гурил 926
- Цагаан будаа 2490
- Шингэн сүү 1894 (литр)
- Элсэн чихэр 2392 (кг)
- АИ-80 (литр)1543
- АИ-92 (литр)1693
- Дизелийн түлш (литр)1657

ХАА-н зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ (мян.төг)

- Ямааны цагаан ноолуур 63 000
- Ямааны бор ноолуур 63 000
- Хонины ноостой нэхий 3 000
- Ямааны ноолууртай арьс 33 500



Тариалсан талбай нийт 1222,3

- Үр тариа 47.7
- Хүнсний ногоо 226.5
- Төмс 421.5
- Тэжээлийн ургамал 526.5
- **Бэлтгэсэн өвс хадлан 56994.05**

Хураасан ургац (тонн)

- Үр тариа 46.1
- Хүнсний ногоо 1612.3
- Төмс 3254.7
- Тэжээлийн ургамал 792.2



Баян-Өлгий аймгийн

7 гайхамшиг

ЦАМБАГАРАВ УУЛ



Цамбагарав уул мөнх цаст уул бөгөөд 4195 метр өндөрт оршдог. Энэхүү уул нь ан амьтнаар баялаг төдийгүй мөс судлалын ач холбогдолтой, нэн ховор ирвэсний өсөлтийг хангахуйц чухал нутаг дэвсгэр аж. Баян-Өлгий, Ховд, аймгийн нутгийн заагаар орших энэ уулыг 2000 онд 1109 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авсан байдаг. Урьд цагт өөлд үндэстнүүд Цамбагарав уулыг Цаст гэдэг байжээ. Нэгэн уран дархан уулын өнгө байдалд нийцүүлж бурхан бүтээгээд түүнийгээ Цамбагарав хэмээн нэрлэж, Цастын өвөр Жинст уулын оройд залснаас хойш Цамбагарав хэмээн нэрийджээ.



БАГА ОЙГАРЫН ЦАГААН САЛААГИЙН ХАДНЫ СҮГ ЗУРАГ



Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын нутагт Алтай таван богдын Бага Ойгар, Усайн Цагаан салаагийн голын савд байдаг. Өргөн нь 500 метр, урт нь 15 километр үргэлжлэх нутагт тархсан хадны сүг зураг бөгөөд шинэ чулуун зэвсгээс хүрэл зэвсгийн үе хамарсан нийт 8000 жилийн түүхийг агуулдаг. Эрт балар цагийн хүмүүсийн хойч үедээ үлдээсэн зурган захиа бөгөөд нийт 10 мянга гаруй сүг зураг тоологджээ.



ТОЛБО НУУР



Өлгий хотоос урагш 45 км-т, Ховд аймаг орох төв замын дагууд Толбо нуур оршидог. Цэнгэг устай, мөстлөгийн гаралтай нуур. Толбо нуур 1000-1500 метрийн харьцах өндөртэй хад асга бүхий нүцгэн уул нуруугаар хүрээлэгдэнэ. Нуурын эргэн тойрны уулсад эртний мөстлөгийн ул мөр тод ажиглагддаг бөгөөд хэд хэдэн жижиг арал байдгаас хамгийн том нь усны мандлаас дөнгөж цухуйх 4 м өндөр Гичгэний толгой юм.



Монгол Алтайн нурууны Алтай Таван Богд ууланд байдаг хамгийн урт Потаниний мөсөн гол юм. Потанин мөсөн голын үед урт нь 10.4 км, талбай нь 24.3 ам/км болсон байна. Урсах явц нь 4365 метрээс 2873 метрт явгадна. Энэ мөсөн голыг 19-р зууны сүүлч 1876-1880 онуудад нээсэн оросын судлаач эрдэмтэн Потанины нэрээр нэрлэсэн. Мөсөн гол гэдэг нь уулархаг, налуу газарт олон мянган жилийн мөс, цас, хуримтлагдан нягтарснаас болж бий болдог. Сүүлийн жилүүдэд олон мөсөн голууд хайлж устах аюулд ороод байгаа Потанины мөсөн гол юм.



БАГА ТҮРГЭНИЙ ХҮРХРЭЭ



Алтай Таван богдын байгалийн цогцолборт үзэсгэлэнт газруудын нэг нь Цэнгэл сумын Хотон, Хурган нуурын хөндийн Бага түргэнийн хавцалд орших “Бага түргэний хүрхрээ” өндөр нь 15 метр бөгөөд тус аймагт оршиж буй хүрхрээнүүдийн хамгийн өндөр нь юм. Хавар, зун уулын ширүүн урсгалт голыг өгсөж энэ нутгийн унаган загас болох Монгол хадран сүрэг сүргээрээ дээшилж түрсээ шахдаг.



ЁЛТЫН САВ ГАЗАР



Ёлтын сав газар нь Алтай суманд байрладаг. Алтай таван богдын байгалийн цогцолборт үзэсгэлэнт газруудын нэг. Уг газар нь унаган төрхөө харьцангуй хадгалсан, дэлхийд ховордсон амьтан, ургамлын тархсан нутаг, ойгоор бүрхэгдсэн үзэсгэлэнт байгальтай мөн эх газрын эрс тэс уур амьсгал зонхилно. Ёлтын сав газар нутгийн ихэнх хэсэг уулархаг ой зонхилдог учраас харьцангуй сэрүүвтэр, чийглэг байдаг.




АЛТАЙ ТАВАН БОГДЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР



Монгол орны хамгийн баруун зах, хамгийн өндөр цэг бүхий Алтай Таван Богд нь “Монгол Алтайн нуруу” Монголын баруун захаас Говь-Алтай аймгийн нутгийг өнгөртөл 900 гаруй км үргэлжилдэг уулсын “хоймор” юм. 1996 оноос 6362 ам км талбайгаар улсын тусгай хамгаалалтад авч цогцолборт газруудын нэгд бүртгэн авсан. Цаг агаарын хувьд хамгийн тогтворгүй газруудын нэг бол Алтай Таван Богд. Нэг өдрийн дотор нар шарж, цас, бороо орж, шуурга тавих нь энгийн үзэгдэл бөгөөд 4 улирлын шинжийг харуулдаг гэсэн үг.




Хүн амын дундаж наслалт






Хүүхэд төрүүлсэн эхчүүдийн тоо, төрсөн хүүхдийн тоо





Хүүхдийн эндэгдлийн тоо, 2012-2017 он





Баян-Өлгий аймагтай холбоотой ВЭБ хуудсууд

- <http://www.bayan-olгии.gov.mn>
- <http://www.bayan-ulгии.nso.mn>



Ядуу, нэн ядуу өрхийн тоо

